



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 37 (174)

Монгол Улсын Их Хурлын
Даргын захирамж:

- УИХ-ын 2000 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай

Яам агентлагийн акт:

- Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн сайд,
Сангийн сайдын хамтарсан тушаал
- Монгол Улсын Хөдөө аж ахуй, Үйлдвэрийн сайдын тушаал

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны аравдугаар сарын 6

№37 (174)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

397. Улсын Их Хурлын 2000 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай Дугаар 40 687

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

398. УИХ-ын 2000 оны 4-р сарын 21-ний өдрийн 36 дугаар тогтоолын үндэслэлийг хэлэлцэх иргэн Ц.Монголын өргөдлөөр үүссэн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай Дугаар 01 688

Гурав. ЯАМ, АГЕНТЛАГИЙН АКТ

399. Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал Дугаар 139/83 690
400. Монгол Улсын Хөдөө аж ахуй, Үйлдвэрлэлийн сайдын тушаал Дугаар А/49 692
401. Монгол Улсын Сангийн сайд, Хөдөө аж ахуй, Үйлдвэрийн сайдын тушаал Дугаар 39, А/37 694
402. Батлан хамгаалахын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал Дугаар 130/88 696

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2000 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын 2000 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 22 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 34 дүгээр тогтоолыг үндэслэн, Монгол Улсын Их Хурлын 2000 оны намрын ээлжит чуулган эхлэхтэй холбогдуулан ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их Хурлын 2000 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг дор дурдсанаар тогтоосугай:

1/ Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох болон нэн даруй устгах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцид нэгдэн орох тухай хуулийн төсөл;

2/ Байгаль орчны төлөв байдлын тухай тайлан;
3/ Дипломат албаны тухай хуулийн төсөл;

4/ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

5/ Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

6/ Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

7/ Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

8/ Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

9/ Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

10/ Аюултай хог хаягдлыг зайлуулахад зөвшөөрөл олгох тухай хуулийн төсөл;

11/ Монгол Улсын 2001 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хуулийн төсөл;

12/ 2001 оны Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

13/ Төрөөс 2001 онд баримтлах мөнгөний бодлогын тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

14/ Татварын зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

15/ Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

16/ Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

17/ Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

18/ Галт зэвсгийн тухай хуулийн төсөл;

19/ Аж ахуйн үйл ажиллагааны бүртгэл, тусгай зөвшөөрлийн тухай хуулийн төсөл;

20/ Монголын Үндэсний радио, телевизийн тухай хуулийн төсөл;

21/ Монголын мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн тухай хуулийн төсөл;

22/ Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн төсөл;

23/ Авилгалтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн төсөл;

24/ Авилгалын эсрэг хуулийн төсөл;

25/ Санхүүгийн хяналт шалгалтын тухай хуулийн төсөл;

26/ Төрийн ордны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;

27/ Ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авах тухай хуулийн төсөл;

28/ Бусад.

2. Дээр дурдсан хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулах, чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангахыг Байнгын хороодын дарга нар, Тамгын газарт үүрэг болгосугай.

3. Чуулганы хуралдаанаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн болон хэлэлцүүлгийн шатанд байгаа хуулийн төслүүдийг холбогдох Байнгын хороодын саналыг үндэслэн дараалал харгалзахгүйгээр хэлэлцүүлсүгэй.

ДАРГА

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр
сарын 8-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС

Улсын Их Хурлын 2000 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 36 дугаар тогтоолын үндэслэлийг хэлэлцэн иргэн Ц.Монголын өргөдлөөр үүссэн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн их суудлын хуралдааныг Цэцийн дарга Н.Жанцан даргалж, гишүүн Ж.Болдбаатар, Д.Чилхаажав, Ж.Бямбажав /илтгэгч/, Ж.Амарсанаа, В.Удвал, Н.Чинбат нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Б.Цэндэхүүг оролцуулан хийв.

Хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Долгор, өргөдөл гаргагч Ц.Монгол нар оролцов.

Хуралдаан Шүүхийн тухай хуулийн

24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 25¹ дүгээр зүйл болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан заалтууд, Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин есдүгээр зүйлийн 1, тавьдугаар зүйлийн 2, тавин нэгдүгээр зүйлийн 1, 2 дахь заалтуудыг зөрчсөн тухай иргэн Ц.Монголын өргөдлөөр үүссэн маргааныг эцэслэн шийдвэрлэв.



Иргэн Ц.Монгол өргөдөлдөө: "Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан "Танхимын тэргүүн шүүгчийг Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно" гэсэн заалт, мөн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хуульд 25¹ дүгээр зүйл нэмж "Улсын Дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгчийн бүрэн эрх" гэсэн зүйл бий болгосон зэрэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна" гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцээд 2000 оны 3 дугаар сарын 13-ны өдөр "1.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, мөн хуулийн 25¹ дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн байна" гэсэн 02 дүгнэлтийг гаргажээ.

Монгол Улсын Их Хурал 2000 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Үндсэн хуулийн Цэцийн 2000 оны 02 дүгнэлтийг авч хэлэлцээд "Үндсэн хуулийн Цэцийн Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 178 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын Дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч" гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэж үзсэнийг хүлээн зөвшөөрч, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, мөн хуулийн 25¹ дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн байна гэснийг зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй гэсэн 36 дугаар тогтоолыг гаргажээ.

Өргөдөл гаргагч Ц.Монгол Үндсэн хуулийн Цэцэд хандан тайлбарлахдаа: Дээд шүүхийн бүрэлдэхүүний хувьд Дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ гэдэг нь ойлгомжтой. Үндсэн хуульд эрүү, иргэний танхимтай байх талаар ямар нэг заалт байхгүй. Иймд Дээд шүүх нь эрүү, иргэний танхимтай байх хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж байна. Шүүхийн тухай хуулийн 25¹ дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 7-д зааснаас үзвэл танхимын тэргүүн шүүгч албан тушаалтан болчихоод байна. Иймд танхимын тэргүүн шүүгч Дээд шүүхийн тэргүүн шүүгчээс давуу эрх эдлэхээр гарсан хуулийн нэмэлт заалтуудыг хүчингүйд тооцох учиртай. Би танхимтай байхыг үгүйсгэхгүй. Харин дарга нь албан тушаалтан болчихоод байна. Ерөнхийлөгч томилох шаардлагагүй. Шүүгчид өөрсдөө сонгож болох юм.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Долгор Үндсэн хуулийн Цэцэд хандан тайлбарлахдаа "Улсын Дээд шүүх нь иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн гэсэн хоёр танхимтай. Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3-т иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн танхимын чиг үүргийг тодорхой зааж өгсөн. Үүнд танхим нь: нэгд шүүн таслах ажлын төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх; хоёрт шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах үүрэгтэй болно. Танхимын тэргүүн

шүүгчийн албан тушаалыг бий болгохдоо дээрх хоёр танхимын ажлыг удирдан зохицуулах, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах үүрэгтэйгээр бий болгосон. Танхимын тэргүүн шүүгч бусад шүүгчдийн адил бүрэн эрхээ эдлэх ба шүүхийн шүүн таслах ажиллагаанд шүүгчдийн бие даан ажиллах явдлыг үгүй болгож, үүргээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс оролцож байгаа явдал биш юм" гэжээ.

Маргааныг хянан шийдвэрлэх явцад Дээд шүүхийн ерөнхий шүүгч Ч.Ганбат албан бичгээр ирүүлсэн тайлбартаа "Монгол Улсын Шүүхийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт нь зөвхөн шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах, шүүн таслах ажлын чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагын улмаас авсан зохион байгуулалтын арга хэмжээ бөгөөд коллеги, танхимын зохион байгуулалтгүй байсан нэг жилийн хугацаанд шүүн таслах ажлын бодлого, шүүх, шүүгчдийн мэргэжлийн удирдлагаар хангах ажил тарамдан хариуцах эзэнгүй болоход хүрсэн юм.

Хуулиар танхимын тэргүүн шүүгчид илүү эрх дарх эдлээгүй бөгөөд зохион байгуулалтын удирдлагын хувьд уг ажлыг нэг гарт төвлөрүүлсэн болно.

Иймд хуулийн дээрх заалт Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй гэж үзэж байна" гэжээ.

Хянавал:

1.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, мөн хуулийн 25¹ дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалттай зөрчилдөж байна гэх үндэслэл тогтоогдохгүй байна. Иймд Улсын Их Хурлын 2000 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 36 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүлээн авах боломжтой байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

1.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, мөн хуулийн 25¹ дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна гэж үзсүгэй.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн энэхүү тогтоол нь эцсийн бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурьдсугай.

**ДАРГА
ГИШҮҮН**

**Н.ЖАНЦАН
Ж.АМАРСАНАА
Ж.БОЛДБААТАР
Ж.БЯМБАЖАВ
В.УДВАЛ
Д.ЧИЛХААЖАВ
Н.ЧИНБАТ**



МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД,

САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН

ТУШААЛ

2000 оны 4 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар 139/83

Улаанбаатар
хот

Суурь үнэлгээ, цагийн тариф батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 185 дугаар тогтоолын 4 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Зам, гүүрийн засвар арчлалтын ажил гүйцэтгэх, төлөөлөх, санхүүжүүлэх, хяналт тавихад жишиг болох "Авто зам гүүрийн засвар, арчлалтын ажлын зардлын суурь үнэлгээ" /УББ-80-201-001/-г нэгдүгээр хавсралтаар, замын ажлын зарим машин, механизмын ашиглалтын цагийн жишиг тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зам гүүрийн засвар арчлалтын суурь үнэлгээ, замын ажлын машин механизмын цагийн

тарифт жил бүрийн хэрэглээний индексийн өөрчлөлтийг тусгах ажлыг норм, нормативыг боловсронгуй болгох сангийн өөрт үлдэх хэсгээс санхүүжүүлэх замаар 2001 оноос эхлэн жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор боловсруулан батлуулж байхыг Барилга Архитектурын газар /Б.Лхагвасүрэн/, Авто замын газар /С.Очирбат/-т тус тус даалгасугай.

**ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН
САЙД**

Г.БАТХҮҮ

САНГИЙН САЙД

Я.ОЧИРСҮХ

*Дэд бүтцийн хөгжлийн сайд, Сангийн
сайдын хамтарсан 139/83 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт*

**Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо
Удирдлагын чанартай баримт бичиг**

АВТО ЗАМ ГҮҮРИЙН ЗАСВАР, АРЧЛАЛТЫН АЖЛЫН ЗАРДЛЫН СУУРЬ ҮНЭЛГЭЭ

УББ 80-201-00

**МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
УЛААНБААТАР ХОТ
2000 он**



УББ-80-201-00

УДИРДЛАГЫН ЧАНАРТАЙ БАРИМТ БИЧИГ
**ЗАМ, ГҮҮРИЙН ЗАСВАР, АРЧЛАЛТЫН АЖЛЫН ЗАРДЛЫН
СУУРЬ НОРМАТИВ
BASIS COST NORMATIVES FOR ROAD AND BRIDGE REPAIR
AND MAINTENANCE WORKS**

№	Барилга байгууламжийн нэр төрөл	Хэмжих нэгж	Засвар арчлалтын ажлын зардлын норматив /төгрөг/	
1	Авто зам	Асфальтон хучилттай	1 км	1821931
		Цементбетонон хучилттай	1 км	2034032
		Хайрган хучилттай	1 км	1679189
		Хөнгөвчилсөн хар хучилттай	1 км	1801913
		Сайжруулсан хөрсөн	1 км	1029624
2	Гүүр	Төмөр бетонон	1 уртааш метр	36811
		Модон	1 уртааш метр	34042

-Энэхүү нормативыг зам, гүүрийн засвар арчлалтын ажлыг гүйцэтгэх, төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавихад жишиг болгон хэрэглэнэ.

-Жил тутам суурь нормативыг индексжүүлэх бөгөөд индексийг баталсан шийдвэр нь энэ баримт бичгийн салшгүй хэсэг болно.

-Тухайн замын ашиглалтад орсон хугацаа, ашиглалтын байдлаас хамааруулан нормативыг тусгай итгэлцүүрээр гаргана.

Дэд бүтцийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2000 оны 4 дүтээр сарын 26-ны өдрийн 139/83 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ЗАМЫН АНГИЛАЛЫН ЗАРИМ МАШИН МЕХАНИЗМЫН
АШИГЛАЛТЫН ЦАГИЙН ЖИШИГ ТАРИФ**

№	Машин-механизмын нэр	Марк	Хүчин чадал бүтээмж	Ашиглалтад орсон он	Балансын үнэ /мян.төг/	1 машин/цагийн 1 бүсийн тариф /төсөл
1.	Экскаватор	CAT330	1.4 м3	1996	187989.0	23896
2.	Экскаватор	CAT320	0.6 м3	1996	125103.0	19043
3.	Экскаватор	JCB	1м3	1996-11	39904.6	1084.3
4.	Автогрейдер	GD-511A	135м.х	1996	101456.5	16240
5.	Ачигч	CAT-938	2.1м3	1996	99513.75	10302
6.	Ачигч	CAT-910	1.2м3	1996	64391.25	17314
7.	Хийн дугуйт индүү	CP-201	10т	1996	52984.8	33661
8.	Доргиурт индүү	CA-251	10т	1996	65562.0	14025
9.	Булт индүү	CS-12	10т	1996	52851.0	11306
10.	Бульдозер	D85A-21	21т	1996	208764.3	28334
11.	Бульдозер	D155-3	32т	1996	293824.1	39700
12.	Бульдозер	D65E-12	15т	1996	147906.5	20854
13.	Асфальто-дэвсэгч	NF-130 DM	2.4-4.5м	1996	133800.0	23933
14.	Битум цацагч	FK-615	25-30 л/м	1996	85632.0	22921
15.	Усны машин	FF3HJSA	6000 л	1996	51408.9	17154
16.	Кран	FH2245A	8 тн	1996	74911.2	18703
17.	Кран	TL-250E	25 тн	1996	157770.9	30137
18.	Асфальтозүсэгч		2м/мин	1995	3000.0	3878
19.	Компрессор	PR-10	10м3/мин	1990	3710.3	5247
20.	Скрепер	D3-546	12м3	1989	20500.0	15927
21.	Автогрейдер	GD-611A	150 м.х	1999	161362	44476
22.	Ачигч	WA-180-3	2.5 м3	1999	99381.5	31436
23.	Экскаватор	PW-150	1.4м3	1999	154879.2	43760
24.	Хийн дугуйт индүү	CP-221	10 тн	1999	103378.8	26181
25.	Усны машин	МДК-4333	6000 л	1999	25000.0	14310



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2000 оны 3 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар А/49

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

"Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай" Монгол Улсын хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 –т заасныг хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ** нь:

1. "Мал, амьтны өвчинтэй тэмцэх, шилжилт хөдөлгөөнийг зохицуулахад хяналт тавих журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг бүх шатны Засаг

дарга нарт, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн улсын хяналтын алба /Ц.Хорлообаатар/-д тус тус даалгасугай.

3. "Мал, амьтны өвчинтэй тэмцэх, шилжилт хөдөлгөөнийг зохицуулахад хяналт тавих журам"-ыг 2000 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

Ч.СОДНОМЦЭРЭН

А/49 дүгээр тушаалын хавсралт

Мал, амьтны өвчинтэй тэмцэх, шилжилт хөдөлгөөнийг зохицуулахад хяналт тавих журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь мал, амьтны өвчинтэй тэмцэх, мал, амьтныг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэг нэгжээс нөгөөд шилжүүлэхэд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон төрийн болон мэргэжлийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

1.2. Мал, амьтны өвчинтэй тэмцэх, шилжилт хөдөлгөөнийг зохицуулахад тавих хяналтыг Хөдөө аж ахуйн улсын хяналтын алба, тэдгээрийн төв, орон нутаг дахь мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нар хэрэгжүүлнэ.

1.3. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээд нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.4. Мал, амьтны өвчинтэй тэмцэх гэдэгт өвчний үүсгэгч шалтгааныг илрүүлэн оношлох, халдварын хязгаарыг тогтоох, хязгаарлалт, хорио цээрийн арга хэмээ авах, өвчтэй мал, амьтныг ялган тусгаарлах, эмчлэх, нядлах, устгах болон өвчнөөс сэргийлж вакцинжуулах, паразиттах өвчний эсрэг угаалга, туулгалт, боловсруулалт, ариутгал халдваргүйжүүлэлт хийх иж бүрэн арга хэмжээг ойлгоно.

1.5. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэг нэгжээс нөгөөд мал, амьтныг дор дурдсан зориулалтаар шилжүүлэхийг мал, амьтны шилжилт хөдөлгөөн гэнэ:

1.5.1. мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилга, угаалга, туулгалт, боловсруулалт, шинжилгээ зэрэг нэгдсэн арга хэмжээнд хамруулах, үржлийн болон хүнс, арилжаа наймаа, бэлгийн зориулалтаар мал, амьтныг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэг нэгжээс нөгөөд шилжүүлэх, тууварлах,

тээвэрлэх;

1.5.2. мал бүхий иргэд оршин суугаа газраасаа өөр аймаг, хот, сумын нутаг дэвсгэрт нүүн шилжин суурьших, отор нүүдэл хийх;

1.5.3. мал, амьтны үзэсгэлэн худалдаа, яармаг зохион байгуулах, цирк тоглуулах;

1.5.4. нэг аж ахуй, суурь, хот айлаас нөгөө аж ахуй, суурь, хот айлд сүрэг сэлбэх, суурь зохион байгуулах зорилгоор мал, амьтныг шилжүүлэх/эрүүл мал, хуц, ухныг ялган сүрэглэх г.м/.

1.6. Мал, амьтны өвчинтэй тэмцэх, шилжилт, хөдөлгөөнийг зохицуулахад тавих хяналтыг хэрэгжүүлэхэд мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч дараах эрх, үүрэгтэй байна:

1.6.1. иргэн, хуулийн этгээд энэхүү журмын 1.5-д заасан үйл ажиллагааг явуулахдаа тухайн орон нутагт гэрээгээр үйлчилж буй мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагаар үзлэг, шинжилгээ хийлгэж гэрчилгээ авсан эсэхэд шалгалт хийх;

1.6.2. тухайн орон нутагт гэрээгээр үйлчилж буй мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагаас энэхүү журмын 1.7.5-д заасан арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавьж хэрэгжилтийг хангуулах;

1.6.3. холбогдох хууль тогтоомжийн дагуу бруцеллёз, сүрьеэ, халдварт цус багасах болон бусад ужиг халдварт өвчний хяналтыг хэрэгжүүлж, өвчний халдварлалтын мэдээг дээд шатны мал эмнэлгийн байгууллагад гаргуулан өгөх;

1.6.4. энэхүү журмын 1.4 дэх хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх үед тухайн орон нутагт гэрээгээр үйлчилж буй мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагаар мал,



амьтанд тусгай ээмэг, им, тамга тавиулах арга хэмжээ авах;

1.6.5. цэвэрлэгээ, ариутгал халдаргүйжүүлэлт, мэрэгчид, хортон шавьжийн устгал зэргийг мал, амьтан бүхий иргэн, хуулийн этгээдээр аж ахуйн үйл ажиллагаатай нь холбогдуулан зохих хууль тогтоомжийн хүрээнд хийлгэх;

1.6.6. халдварт, паразиттах өвчин гарсан болон гарч болзошгүй нутаг дэвсгэрээс тухайн өвчний үүсгэгчийг тараах магадлалтай мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, сэг зэм, бусад зүйлсийг шилжүүлэн хөдөлгөх аливаа үйлдлийг хязгаарлах, хориглох, халдваргүйжүүлэх зэрэг арга хэмжээг иж бүрэн авч хэрэгжүүлэх;

1.6.7. мал, амьтны шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан гарч болох халдварт өвчний хор хөнөөл, түүнээс сэргийлэх талаар иргэн, хуулийн этгээдийг ухуулга, сурталчилгаа, мэдээлэлээр хангах;

1.6.8. харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд мал туувар, тээвэрлэлтийн байдалд хяналт тавих.

1.7. мал, амьтны өвчинтэй тэмцэх, шилжилт хөдөлгөөнийг зохицуулахад тавих хяналтыг хэрэгжүүлэхэд тухайн орон нутагт гэрээгээр үйлчилж буй мал эмнэлгийн үйлчилгээний байгууллага дараах эрх, үүрэгтэй байна:

1.7.1. харьяалах нутаг дэвсгэртээ, мал, амьтны халдварт, паразиттах өвчний гаралт, тархалт, голомтын бүртгэл, судалгаа, картыг тогтмол хөтөлж байх.

1.7.2. өвчний гаралт, тархалт, голомтын бүртгэл, судалгаа, зураглал, үзлэг, шинжилгээний дүгнэлтэд үндэслэн халдварт, паразиттах өвчнөөр тайван, эрүүл суурь, сүргийн бүртгэл хөтөлж, паспортжуулах;

1.7.3. мах боловсруулах үйлдвэр, мал нядалгааны газарт бэлтгэсэн болон үржлийн зориулалтаар худалдан авах ба худалдах мал, амьтанд халдварт, паразиттах, ялангуяа бруцеллөз, сүрьеэ, халдварт цус багасах болон бусад уйж халдварт өвчнийг оношлох лабораторийн шинжилгээ заавал хийж, дүгнэлт гаргаж байх;

1.7.4. экспортлох, импортлох мал, амьтныг тодорхой хугацаанд /14-30 хүртэл хоног/ хорио, хязгаарлалтад байлгаж, Олон улсын болон улс хооронд байгуулсан мал эмнэлэг, хорио цээрийн гэрээ, хэлэлцээрт заасан нөхцөлийн дагуу мал эмнэлгийн үзлэг, шинжилгээ хийж, эрүүл болох нь тогтоогдсон үед зохих арга хэмжээ авах;

1.7.5. халдварт өвчин тархан

дэлгэрэхээс урьдчилан сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний явц, үр дүнгийн талаар дээд шатны мал эмнэлгийн байгууллага, хамаарах баг, сумдын Засаг дарга нарт мэдээлэх;

1.7.6. энэхүү журмын 1.7.5-д заасан арга хэмжээг явуулахаас 10 хоногийн өмнө доорхи мэдээллийг олон нийтэд мэдээлэх бөгөөд онцгой тохиолдолд уг хугацааг 3 хоног хүртэл богиносгож болно:

-уг үйл ажиллагааны зорилго, хамруулах нутаг дэвсгэр;

-хамрагдах мал, амьтны төрөл;

-үзлэг, шинжилгээ, тарилга, туулгалт, угаалга, боловсруулалт, эмчилгээний төрөл, арга, хэлбэр.

1.8. Мал, амьтны өвчинтэй тэмцэх, шилжилт хөдөлгөөнийг зохицуулахад тавих хяналтыг хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд дараах үүрэгтэй байна:

1.8.1. тухайн орон нутагт гэрээгээр үйлчилж буй мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагаар үзлэг, шинжилгээ хийлгэж гэрчилгээ авсны үндсэн дээр энэхүү журмын 1.5-д заасан үйл ажиллагааг явуулах;

1.8.2. үржлийн мал, амьтан худалдан авах, худалдах тохиолдолд мал эмнэлгийн лабораторийн шинжилгээг заавал хийлгэж, эрүүл болох нь тогтоогдсон нөхцөлд тухайн орон нутагт гэрээгээр үйлчилж буй мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагаас олгосон гэрчилгээтэйгээр шилжилт хөдөлгөөн хийж байх;

1.8.3. орон нутгийн засаг захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу мал, амьтны өвчинтэй тэмцэх арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулах;

1.8.4. мал, амьтны хашаа, байр, бэлчээр, уст цэг зэргийг ариутгал халдаргүйжүүлэлтэд хамруулах, шаардлагатай тохиолдолд халдварт өвчтэй болон өвчний халдвар тараах магадлал бүхий мал, амьтныг нядлах, устгах, хүсэн мал, амьтны сэг зэмийг шатаах, булах, халдваргүйжүүлэх арга хэмжээ авах;

1.8.5. өөрийн болон зэргэлдээ суурь, сүргийн мал, амьтны өвчний байдлын талаар орон нутгийн засаг захиргаа, тухайн орон нутагт гэрээгээр үйлчилж буй мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагад байнга мэдээлж байх.

Хоёр. Хариуцлага

2.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

 2000 оны 3 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 39,А/37

 Улаанбаатар
хот

Кассын машин ашиглах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 91 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ** нь:

1. "Кассын машин ашиглах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилт, явцад байнгын хяналт тавьж, ажлын үр дүнгийн талаар улирал бүр Сангийн сайдын зөвлөлд мэдээлж байхыг Үндэсний татварын ерөнхий газар /Д.Батжаргал/-д даалгасугай.

3. Худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хүрээнд энэхүү тушаалын хэрэгжилтийг хамруулж байхыг Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний улсын хяналтын алба /Л.Шаснаабадраа/-нд үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авч,

татварын албанд бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагуудад кассын машин заавал хэрэглүүлэх арга хэмжээ авахыг нийслэл, аймаг, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн хяналт шалгалтын газар /Г.Зинаамъядар/, Сангийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Ц.Даваасүрэн/, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Бодлогын зохицуулалтын газар /Я.Балгансүрэн/-т даалгасугай.

САНГИЙН САЙД
Я.ОЧИРСҮХ
**ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ҮЙЛДВЭРИЙН САЙД**
Ч.СОДНОМЦЭРЭН
39,А/37 тоот тушаалын хавсралт

КАССЫН МАШИН АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Журмын зорилт нь иргэн, хуулийн этгээд худалдаа, үйлчилгээнд бэлэн мөнгөний гүйлгээг хэрэглэх нөхцөлд кассын машиныг ашиглах, ажиллуулах, бүртгэх, борлуулалтын баримтыг кассын машинаар боловсруулах, кассын машин ашиглах үйл ажиллагаатай холбогдсон эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, тэдгээрийг зохицуулахад оршино.

Хоёр. Кассын машин хэрэглэгч

2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээнд бэлэн мөнгөний гүйлгээг хэрэглэж байгаа өмчийн бүх төрөлд хамаарагдах аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газар, жилийн 5 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуй эрхлэгч иргэн кассын машин заавал хэрэглэнэ.

2.2. Валютын арилжаа эрхлэгчид кассын машин заавал хэрэглэнэ.

Гурав. Кассын машин хэрэглэгчийн эрх, үүрэг, хориолох зүйл

3.1. Кассын машин хэрэглэгчийн эрх:

3.1.1. кассын машины хэвийн үйл ажиллагаа алдагдах буюу эвдэрсэн тохиолдолд техникийн засвар, үйлчилгээ хариуцсан ажилтанг дуудах;

3.1.2. хэрэглэгчээс үл хамаарах шалтгаанаар кассын машиныг ажиллуулах боломжгүй /цахилгаан тасрах гэх мэт/ тохиолдолд харъяалагдах татварын албанаас олгосон борлуулалтын баримтаар худалдаа, үйлчилгээ явуулах. /Борлуулалтын баримт нь татварын албаны тусгай нууцлалтай, дугаартай байна/;

3.2. Кассын машин хэрэглэгчийн үүрэг:

3.2.1. кассын машинаа харъяалагдах татварын албанд бүртгүүлэх;

3.2.2. кассын машин алдаатай, буруу ажилласан, эвдэрсэн тохиолдолд шалтгааныг тодорхойлон акт үйлдэж харъяалах татварын албанд заавал мэдэгдэх;

3.2.3. худалдаа, үйлчилгээнд кассын машиныг тогтоосон журмын дагуу ашиглах;

3.2.4. худалдаа, үйлчилгээ үзүүлснийг гэрчлэх кассын машинаар боловсруулсан баримтыг худалдан авагчид заавал олгох;

3.2.5. татварын албаны байцаагч, кассын



машины засвар үйлчилгээ хариуцсан ажилтныг кассын машин дээр ажиллахад саад учруулахгүй байх, шаардлагатай дэмжлэг, тусалцаа үзүүлэх;

3.2.6. барааны үнийг бараа тус бүр дээр үнэн зөв бичиж тэмдэглэх, үйлчлэгээний үнийн жагсаалтыг үйлчлүүлэгчдэд харагдахуйц газар байрлуулах;

3.2.7. кассын машины лац, ломбо, бусад тэмдэглэлийг хөдөлгөх, эвдэх, өөрчлөхгүй байх;

3.2.8. кассын машиныг хэвийн ажиллуулах нөхцөлийг хангах үүднээс бараа, үйлчилгээнд зураасан кодын систем нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.2.9. кассын машиныг хариуцан ажиллах болон орлон ажиллах ажилтанг томилох;

3.3. Кассын машин хэрэглэгчдэд дараахь зүйлийг хориголно:

3.3.1. кассын машин ашиглахгүйгээр худалдаа, үйлчилгээ хийх;

3.3.2. кассын машиныг ажиллах боломжтой үед нь зориудаар ажиллуулахгүй байх;

3.3.3. кассын машинаар боловсруулсан баримтыг үйлчлүүлэгчдэд олгохгүй байх;

3.3.4. кассын машиныг хариуцан ажиллах болон орлон ажиллахаар томилогдсон ажилтнаас өөр хүн ажиллуулах;

3.3.5. кассын машины программыг дур мэдэн өөрчлөх;

3.3.6. татварын албанаас кассын машинд тавьсан лац, ломбыг хөдөлгөх, эвдэх, өөрчлөх.

Дөрөв. Татварын албаны эрх, үүрэг

4.1. Татварын албаны эрх:

4.1.1. энэ журамд заасан техникийн шаардлага хангасан кассын машиныг бүртгэж, худалдаа, үйлчилгээнд ашиглах эрх олгох;

4.1.2. кассын машинтай холбогдолтой асуудлаар хяналт, шалгалт хийх, илэрсэн зөрчлийн талаар тайлбар, лавлагаа гаргуулах;

4.1.3. энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжуудыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад татварын хуулиудад заасны дагуу торгууль хүлээлгэх, банкны харилцах дансыг хаах, үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулах эрхийг нь сунгахгүй байх, шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоох асуудлыг холбогдох байгууллагад тавих.

4.2. Татварын албаны үүрэг:

4.2.1. иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь кассын машин ашиглахгүйгээр худалдаа, үйлчилгээ хийж байгаа эсэх, кассын машиныг буруу ашиглаж байгаа эсэхэд тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг харъяалах татварын алба хяналт тавих;

4.2.2. үйлчлүүлэгчдэд борлуулалтын баримтыг

хэрхэн олгож байгаад хяналт тавих.

Тав. Кассын машин ажиллуулах зарчим

5.1. Кассын машин нийлүүлэгч нь кассын машиныг ашиглах заавар, техникийн паспортыг хэрэглэгчдэд албан ёсоор хүлээлгэн өгнө. Кассын машиныг ашиглах заавар, техникийн паспорт болон бусад бичиг баримтыг монгол хэл дээр боловсруулсан байна.

5.2. Кассын машины паспорт нь кассын машинаа ашиглалтад оруулах, дунд болон их засварт оруулахад кассын машины хамт дагалдана. Кассын машины паспорт, кассирын ном, бусад бичиг баримтууд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захирал, ерөнхий нягтлан бодогч, нягтлан бодогч нарт /цаашид хариуцлагатай ажилтан/ хадгалагдаж байна.

5.3. Кассын машиныг ашиглалтад оруулахдаа харъяалагдах татварын албанд мэдэгдэж, тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг хариуцдаг татварын улсын байцаагч, кассын машинд засвар үйлчилгээ хийх эрх бүхий мэргэжилтэн, мөн аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагатай ажилтан, кассир байцана.

5.4. Кассын машины мэргэжилтэн дараахь эрх, үүрэгтэй:

5.4.1. кассын машин зөв ажиллаж байгааг шалгах;

5.4.2. кассын машиныг ажилд турших;

5.4.3. кассын машиныг ашиглалтад оруулах тодорхойлолт гаргах.

Зургаа. Монгол Улсын нутаг дэвсгэрт ажиллуулах кассын машинд тавигдах техникийн шаардлага

6.1. Кассын машиныг сонгон шалгаруулахдаа техникийн найдвартай ажиллагаа, бат бөх чанар, программ хангамжийг монголын нөхцөлд /монгол хэл дээр/ тохируулсан байх, үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн энэ чиглэлд ажилласан туршлага, засвар үйлчилгээг бүрэн хариуцан хийх, сэлбэг хэрэгслээр хангах, кассын машины болон сэлбэг хэрэгслийн үнэ харьцангуй хямд байх зэргийг харгалзана. Кассын машин нь дараахь техникийн шаардлагуудыг хангасан байвал зохино:

6.1.1. Аж ахуйн нэгж, байгууллагын /дэлгүүрийн/ нэр, татвар төлөгчийн дугаар, тасгийн дугаар, тухайн кассын машины үйлдвэрийн дугаар, бүртгэлийн дугаар, он, сар, өдөр гэх мэт худалдааны болон бусад мэдээллийг агуулсан байх;

6.1.2. Тасалбарын эхний мөр тус бүрд нь 24 үсэг, тэмдэгтээр, барааны үнийг 8 орноос дээш



тоогоор оруулах боломжтой байх;

6.1.3. Кассын машин нь тэжээлээс үл хамааран мэдээллийг удаан хугацаагаар хадгалах санах ойн байгууламжтай байх;

6.1.4. Нэмэгдсэн өртгийн албан татварын дүнг талондоо тусад нь ялгаж бичдэг байх;

6.1.5. Санах ойг 5 жилээс доошгүй хугацаанд сольдог байх;

6.1.6. 4-өөс дээш тасагтай ажилладаг байх /тухайн тасгийг нэг төрлийн барааны, олон төрлийн барааны гэх мэтээр программчилж болох/;

6.1.7. Кассирын буруу үйлдэл болон бусад буруу /хяналтын лент тасрах/ ажиллагааг алдааны дохио өгч мэдээлдэг байх;

6.1.8. Татварын байцаагч, эрх бүхий байгууллагын мэргэжилтэн, кассын ажилтан тус тусын паролиор кассын машинд нэвтэрдэг байх;

6.1.9. Дэвсгэртийн болон зоосны тасалгаануудтай мөнгөний хайрцагтай байх;

6.1.10. Мөнгө буцааж олгох буюу талоныг хүчингүй болгож тэмдэглэдэг байх;

6.1.11. Цахилгаан тасарсан буюу гэмтэлтэй үед өөрийн нэмэлт цахилгаан үүсгүүртэй /батарей, UPS-тэй/ байх;

6.1.12. Ажиллах орчны температур /-5°C-+50°C/ байх;

6.1.13. Орчны чийгшилт 10% -90%- иас багагүй байх;

6.1.14. Баталгаат хугацаа 1 жилээс дээш байх;

6.2. Кассын машин нь компьютерт холбогдон "WINDOWS" программын орчинд ажилладаг, тухайн аж ахуйн нэгж, байгууллагынхаа дотоодын сүлжээ, электрон жин хэмжүүрт холбогддог, зураасан кодыг ашиглаж уншдаг байх зэрэг нэмэлт шаардлагуудыг хангаж байвал зохино.

6.3. Кассын машин нийлүүлэх, түүний техник засвар, үйлчилгээг эрхлэхээр шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагатай Үндэсний Татварын Ерөнхий

газар харилцан гэрээ байгуулна.

Долоо. Журам зөрчигчдөд хүлээлгээх хариуцлага

7.1. Энэ журам болон холбогдох бусад хууль тогтоол, журмуудыг зөрчсөн татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дараахь тохиолдолд дор дурдсан хэмжээний торгууль, шийтгэл хүлээлгэнэ:

7.1.1. кассын машин суурилуулсан боловч шалтгаангүйгээр ажиллуулаагүй, кассын талон олгохгүйгээр худалдаа, үйлчилгээ явуулсан тохиолдол тутамд иргэнд 50000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000 хүртэл төгрөгөөр торгоно.

7.1.2. эвдэрсэн буюу алдаатай, буруу ажилладаг кассын машин ашигласан бол тохиолдол тутамд иргэдийг 50000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000 хүртэл төгрөгөөр торгоно.

7.1.3. барааны үнийг бараа тус бүр дээр бичиж тэмдэглээгүй, үйлчилгээний үнийн жагсаалтыг үйлчлүүлэгчдэд харагдахуйц газар байрлуулаагүй тохиолдол тутамд иргэдийг 50000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000 хүртэл төгрөгөөр торгоно.

7.1.4. хэрэглэгч кассын машин хэрэглэхгүйгээр худалдаа, үйлчилгээ явуулсан бол тохиолдол тутамд иргэдийг 50000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000 хүртэл төгрөгөөр торгоно.

7.2. Ногдуулсан торгууль, шийтгэлийг кассын машин хэрэглэгч ажлын 5 хоногт багтаан төлнө.

Найм. Журам хүчин төгөлдөр болох

8.1. Энэхүү журам 2000 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2000 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр

Дугаар 130/88

Улаанбаатар хот

Маягт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 211 дүгээр тогтоолоор батлагдсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-ын тавын 15-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

"Аймаг, нийслэлийн цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах ажлын гүйцэтгэлийн тайлан"-гийн маягтыг 1 дүгээр

хавсралтын, "Сум, дүүргийн цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах ажлын гүйцэтгэлийн тайлан"-гийн маягтыг 2 дугаар хавсралтын ёсоор баталсугай.

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Ш.ТҮВДЭНДОРЖ

САНГИЙН САЙД

Я.ОЧИРСҮХ

